



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 22

Шарга

**Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн  
хэрэгжилтийг хангах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулын 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Архидан Согтуурахтай Тэмцэх Тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь заалт, Улсын Их Хурлын 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 48 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 04 сарын 21-ний өдрийн 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын хэмжээнд сар бүрийн "Нэгэн", 7 хоног бүрийн "Лхагва" гарагт архи, согтууруулах ундаагаар үйлчилдэггүй, худалддаггүй өдөр болгон тогтоосугай.
2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, Архи худалдаалах, үйлчлэхийг хориглосон өдрүүдэд худалдаа, үйлчилгээний газруудад хяналт тавих ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сумын засаг дарга /Д.Түмэнбаяр/- т үүрэг болгосугай.
3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, архитай холбоотойгоор гарсан зөрчлийн талаар сар бүрийн эцэст Иргэдийн төлөөлөгчдийн ажлын албанд ирүүлж Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Цагдаагийн хэсэгт, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарын бичгийн дарга Л.Сэрсмаа нарт тус тус үүрэг болгосугай.
4. Уг тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 11 дүгээр сарын 14- ний өдрийн 39 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР

